



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 167

Улаанбаатар хот

Өмч хамгаалах зөвлөлийг
байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 86 дугаар тогтоолын хавсралтаар “Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам”-ын 2.1 дэх заалт, Иргэний нисэхийн ерөнхий газрын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2021 оны 01 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэний нисэхийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтэц өөрчлөгдсөнтэй холбоотойгоор “Өмч хамгаалах зөвлөл”-ийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Дарга:	Иргэний нисэхийн үндэсний төвийн дэд дарга (Нисэх буудлын үйлчилгээ хариуцсан)
Нарийн бичгийн дарга:	Санхүү, эдийн засаг төлөвлөлтийн газрын Үйлдвэрлэлийн нягтлан бодох бүртгэлийн албаны үндсэн хөрөнгө хариуцсан ахлах нягтлан бодогч
Гишүүд:	Санхүү, эдийн засаг төлөвлөлтийн газрын дарга Агаарын навигацийн үйлчилгээний газрын менежер “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын Үйлдвэрлэл хариуцсан дэд захирал Аюулгүй байдал, хамгаалалтын албаны дарга Сэргээн засах амралтын дарга Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албаны дэд дарга Холбоо, навигаци, ажиглалтын албаны ерөнхий инженер

2.

2. Иргэний нисэхийн үндэсний төв болон түүний харьяа салбар, нэгжүүдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дуусаж, элэгдэл хорогдлын шимтгэлээрээ балансын үнээ нөхсөн, нөхөөгүй боловч гэнэтийн осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй, эдийн засгийн хувьд үр ашиггүй нь нотлогдсон үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, шилжүүлэх, устгах ажлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 86 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам” болон холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Өмч хамгаалах зөвлөл (Н.Мягмарсүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.МӨНХЖАРГАЛ